



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 20 өдөр

Дугаар A/498

Булган сум

┌ Зөвлөлдөх уулзалт зохион байгуулах тухай ┐

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 419 дүгээр “Хот хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Хөдөөгийн сэргэлт-Хөрөнгө оруулагчдын чуулганы бэлтгэл” орон нутгийн зөвлөлдөх уулзалтыг 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Давааням), Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т даалгасугай.

2.Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 900,000 (есөн зуун мянга) төгрөгийг “Хот хөдөөгийн сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх Нээлттэй Булган” хөтөлбөр арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6323010497

06 дугаар сарын 20-ны өдрийн 4498 дугаар захирамжийн хавсралт



“ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТ-ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ЧУУЛГАНЫ БЭЛТГЭЛ”
ОРОН НУТГИЙН ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТЫН ТӨСӨВ

Д/д	Шаардлагатай зардал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Үнэ /төгрөг/	
				Нэг бүр	Нийт
1	2	3	4	5	6
1	Бургер	Ширхэг	100	5000	500 000
2	Цай, кофе	Ширхэг	100	2000	200 000
3	Цэвэр ус	Ширхэг	100	2000	200 000
НИЙТ				900 000	